

## Статистикийн хэлтсийн 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 02-ны өдрийг хүртлэх 5 хоногт хийсэн ажлын товч мэдээ

2019.05.02

Өлгий хот

1. Цаг үеийн шаардлагаар ҮСХ-оос нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь дамжуулсан болно.

2. Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт цуглуулж, төв руу дамжуулав. Мөн Хэлтсийн портал сайтад 7 хоногийн үнийн өөрчлөлтийн мэдээг оруулав.

3. Ажиллах хүчний судалгааны 3-р улирлын тодруулгыг, судлаач, болон судалгаанд хамрагдсан өрхүүдээс тодруулан ҮСХ-нд хүргүүлээ.

4. 1 дүгээр улирлын мэдээ болох Аялал жуулчлал, Мал эмнэлэг Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ, Худалдаа, Сүм хийд, эрдэм шинжилгээ, судалгааны мэдээний тодруулгыг хугацаанд нь тодруулан Үндэсний статистикийн Хороонд хүргүүлэв.

5. Судлаач нарын цуглуулсан ажиллах хүчний судалгааны материалыг хянаж, графикт хугацаанд нь онлайнаар ҮСХ-нд хүргүүлсэн.

6. ХАӨМСанд Өлгий сумын 13 багийн дотоод шилжих хөдөлгөөнүүдийг хийж, мөн ургийн овгийн алдааг эхсэл файлд нэгтгэн Үндэсний статистикийн Хорооны мэдээлэл технологийн газарт ургийн овгийн алдааг засуулахаар хүргүүлэв.

7. Төсвийн гүйцэтгэлийн зарлагын 4 дүгээр сарын мэдээг гаргаж хугацаанд нь Үндэсний статистикийн хорооны санхүүгийн хэлтэст хүргүүлээ.

8. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс статистик тоон мэдээллийг гаргаж өгөхийг хүссэний дагуу холбогдох тоон мэдээллийг тус тус гаргаж өгөв.

9. Мал төллөлт, төл бойжилт, Том малын зүй бус хорогдол, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сарын мэдээг холбогдох газруудаас авч нэгтгэн ажиллаж байна.

10. “Ажил эрхлэлтийн байдал-2018 он” танилцуулгын хүснэгт бэлтгэж тойм бичиж байна.

Бусад ажил хэвийн явагдаж байна

**Статистикийн хэлтэс**